




**МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ
СҮЛЖЭЭ ХХК**



**2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Зураг 2. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ



Нэг. Сувгийн үйлчилгээ

Тоон суваг түрээслүүлэх үйлчилгээг төрийн болон бизнесийн 18 байгууллагатай 23 гэрээний хүрээнд 368 суурин газарт (аймаг, сум, баг, боомт) 93,062 Мбит/с урсгал борлуулан үйлчилгээ үзүүлж байна.

Хоёр. Интернэтийн бөөний үйлчилгээ

Интернэтийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий 10 компанитай гэрээ байгуулж, 10,637 Мбит/с интернэт урсгал борлуулан ажиллаж байна.

Гурав. Шөрмөс түрээслүүлэх үйлчилгээ

Хотын доторх шөрмөс түрээслүүлэх үйлчилгээг 7 байгууллагатай гэрээ байгуулан 57,4 км шөрмөс түрээслүүлж байгаа бол Хот хооронд шөрмөс түрээслүүлэх үйлчилгээг 6 компанитай хамтран ажиллаж 8,503.8 км шөрмөс түрээслүүлэх үйлчилгээ үзүүлж байна.

Дөрөв. Тоног төхөөрөмжийн байр, цамхаг, оффисын байр талбай түрээсийн үйлчилгээ

Тоног төхөөрөмжийн байр, цамхаг түрээслүүлэх байр талбайн түрээсийн үйлчилгээний хүрээнд нийт 93 түрээслэгчтэй 304 байршилд түрээсийн гэрээгээр хамтран ажиллаж байна.

Улаанбаатар хот, 20 аймаг, 2 дүүрэг, 22 суманд нийт 5,630 мкв бүхий байр талбайг түрээслүүлж 181 гэрээ байгуулж, хамтран ажиллаж байна.

Тав. Худаг, сувагчлалын үйлчилгээ

Улаанбаатар хотын хэмжээнд нийт 120 түрээслэгчтэй давхардсан тоогоор 6354 чиглэлд 6,137 км сувагчлал, 83,244 ш худаг, 5,159ш агаарын багана түрээслүүлэн гэрээгээр хамтран ажиллаж байна.

Зургаа. Техник менежмент

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь Монгол улсын хэмжээнд Улаанбаатар хот, 21 аймаг, 392 сум, суурин газрыг хамарсан мэргэшсэн хүний нөөцийн боломжид тулгуурлан харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын 1808 сайтын ашиглалт үйлчилгээ болон тэдгээр сайтууд дээрхээс гадна алслагдсан багуудад байрлах сайтуудын сүлжээний найдвартай ажиллагааг хангах үүднээс 2000 гаруй удаагийн сүлжээний гэмтэл саатал, сүлжээний өргөтгөл, шинэ сайтын хайгуул, сүлжээний чанар шалгах, тоног төхөөрөмжийг зөөвөрлөн шилжүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Долоо. Мэдээллийн аюулгүй байдлын аудитын үйлчилгээ

Зайлшгүй Мэдээллийн аюулгүй байдлын аудит болон баталгаажуулалт хийлгэх “Онц чухал дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт”-д орсон 216 байгууллагад тус үйлчилгээг үзүүлэхээр ажиллаж байна. Аудитын багаа чадавхжуулах ажлыг эрчимжүүлж энэ онд Диспетчерийн үндэсний төв ТӨХХК, Дархан-Уул аймгийн Дархан дулааны сүлжээ ТӨХК болон СЭМҮТөвийн “Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх” хамтран ажиллах гэрээ байгуулж ажлаа бүрэн дуусгаад байна.

1.3 ТЕХНИК ТЕХНОЛОГИ, СҮЛЖЭЭНИЙ БАГТААМЖ, БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант хугацаанд үндсэн сүлжээний бэлэн байдлын үзүүлэлт (KPI) 99.95, өгөгдлийн сүлжээний бэлэн байдлын үзүүлэлт (KPI) 99.98, Улс хоорондын сүлжээний бэлэн байдлын үзүүлэлт (KPI) 99.98, Кабель шугам (KPI) 99.82 гарч нийт сүлжээний бэлэн байдлын үзүүлэлтийг хангаж ажилласан байна. Компанийн “Гэмтэл саатлын нөхцөл байдлын үед ажиллах журам”-д заасны дагуу сүлжээний чанарын бэлэн байдлын түвшинг дараах байдлаар тогтоосон.

Компанийн хэмжээний дэд бүтэц, дамжуулах байгууламж, өгөгдлийн сүлжээ, худаг сувагчлалын байгууламж, кабель шугамын байгууламжийн үйл ажиллагааг хэвийн найдвартай явуулахад технологи болон чанарын удирдлагаар хангаж, сүлжээний бэлэн байдлын үзүүлэлт KPI үнэлгээг тооцон гаргаж ажиллалаа.

Хүснэгт 1. Сүлжээний чанарын бэлэн байдлын түвшин

Төрөл	Хэмжих нэгж	Чанарын түвшин /KPI/	Гүйцэтгэл /KPI/
Үндсэн сүлжээний бэлэн байдал	%	≥99.95	99.95
Өгөгдлийн сүлжээний бэлэн байдал	%	≥99.95	99.98
Улс хоорондын сүлжээний бэлэн байдал	%	≥99.98	99.98
Кабель шугамын бэлэн байдал	%	>98.5	99.82


Тайлант хугацаанд “Гэмтэл саатлын нөхцөл байдлын үед ажиллах журам”-д заасны дагуу нийт сүлжээний бэлэн байдлын үзүүлэлтийг хангаж ажилласан.

Үндсэн сүлжээнд: 2024 онд 95 удаагийн гэмтэл гарч 954 цаг үргэлжлэн 216873 Мбит/с урсгал саатсан. Үүнээс зай тэжээлийн гэмтэл 5 удаа, тоног төхөөрөмжийн гэмтэл 4 удаа, шилэн кабелийн гэмтэл 86 удаа гарч засагдсан.

Хүснэгт 2. 2024 оны Үндсэн сүлжээнд гарсан гэмтлүүд

Төрөл	Удаа	Гэмтэл үргэлжилсэн хугацаа цаг	Саатсан урсгал Мбит/с
Зай тэжээлийн гэмтэл	5	51	5230
Тоног төхөөрөмжийн гэмтэл	4	65	404
Шилэн кабелийн гэмтэл	86	836	211239
Нийт дүн	95	952	216873

Зураг 3. Гарсан гэмтэл



Зай тэжээлийн гэмтлийн хувьд: Тайлант хугацаанд зай тэжээлээс шалтгаалж 5 удаагийн гэмтэл гарсан ба гэмтлийн 60%-ийг дизель генераторын ажиллагаа доголдсон болон батарей нурснаас сүлжээнд тасалдал үүссэн байна. Эрчим хүчний гэмтлээс шалтгаалж түлшний хангалтгүй болсон гэмтэл 1 удаа, галын аюулгүй байдал алдагдсанаас шалтгаалсан гэмтэл 1 удаа тус тус гарсан.

Зай тэжээл нь үндсэн сүлжээг найдвартай байнгын тогтвортой байлгах гол бүрэлдэхүүн хэсгийн нэг бөгөөд компанийн технологийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтад тогтмол тус системийн шинэчлэлийг үе дараалалтай тусган сайжруулах, өргөтгөх, сольж шинэчилж байна. Үүний үр дүнд гарч болзошгүй гэмтэл саатлаас урьдчилан сэргийлэх, мөн ИТА нар ашиглалтын үеийн ажиллагааны горимд тогтмол хяналт тавьж, зай тэжээлийн гэмтэл эрс буурч байна.

Тоног төхөөрөмжийн гэмтлийн хувьд: Тайлант хугацаанд тоног төхөөрөмжийн 4 удаагийн гэмтэл гарсан ба үүнээс 75% нь тоног төхөөрөмжийн нөөцгүй улмаас систем тасарч нөөц бүрдүүлэлт хийснээр систем сэргэсэн. Программ хангамжийн гэмтэл 1 удаа гарсан. Үндсэн сүлжээ болон өгөгдлийн сүлжээ нь SDH, DWDM болон өгөгдлийн IP технологид суурилсан дамжуулах тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байна. Эдгээр тоног төхөөрөмжүүд нь орон нутгийн салбаруудын хэмжээнд давхардсан тоогоор 700 орчим байгаа ба тэдгээрээр харилцагч компаниудын үйлчилгээг дамжуулан түгээж байна.

Манай компанийн магистрал дамжуулах сүлжээний топологи нь цагирган /ring/ бүтэцтэй тул гэмтэл саатал гарсан үед 1+1 хамгаалалт болон нөөц тойруу холболтоор трафик урсгалуудыг дамжуулан тасалдал үүсгэхгүй байх тохиргоотой байдаг. Дамжуулах тоног төхөөрөмжийн ажиллагаа тогтвортой хэвийн байгаа боловч DWDM, SDH-ийн төхөөрөмжийн зарим картууд гэмтсэн байгааг нөхөн авч нөөц бүрдүүлэх шаардлагатай.


Шилэн кабелийн гэмтлийн хувьд: Тайлант хугацаанд шилэн кабелийн 86 удаагийн гэмтэл гарсан ба үндсэн сүлжээнд гарсан гэмтлийн 90.5%-ийг эзэлж байна. Дулааны улиралд зам засварын бүтээн байгуулалт, иргэд аж ахуй нэгжүүд газар шорооны ажил хийж эхэлсэнтэй холбоотойгоор шилэн кабель тасалсан гэмтлүүд ихэсдэг. Энэ нь сум суурин газарт гаднын байгууллага, хувь хүн манай холбооны салбарт урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авахгүй газар шорооны ажлыг хийж байгаад шилэн кабель гэмтээсэн гэмтлүүд ихэнх хувийг эзэлж байна. Мөн энэ онд их хэмжээний хур тунадас орсон жил байсан тул үер ус, байгалийн хүчин зүйлийн улмаас шилэн кабель гэмтсэн гэмтлүүд их гарсан. Нийт шилэн кабелийн гэмтлийн 59%-ийг сум суурин газраас 5 км дотор гарсан шилэн кабелийн гэмтэл эзэлж байна.

Уг гэмтлийн 46%-ийг байгууллага, аж ахуй нэгжүүд, 17.7%-ийг иргэн, хувь хүн газар шорооны ажил хийж байгаад шилэн кабель тасалсан гэмтлүүд эзэлж байна. Байгаль цаг уурын нөлөөтэй гарсан гэмтэл 16.2%-ийн эзэлж байна.

Дулааны улиралд автозам, зам гүүр болон бусад инженерийн байгууламжийн шугам сүлжээний өргөтгөл, засварын ажилтай холбоотой 4-р сараас 10-р сарын хооронд шилэн кабелийн гэмтэл хамгийн ихээр гардаг. Эдгээр ажлуудыг гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүс манай компанийн хот хоорондын шилэн кабель таарч байгаа газруудад заавал техникийн нөхцөл гаргуулж, ажил эхлүүлэх зөвшөөрөл авч хяналтан доор ажлыг гүйцэтгэдэг бол энэ төрлийн гэмтлийг 63% бууруулах боломжтой байна.

Шилэн кабелийг гадны нөлөөгөөр тасрах эрсдэлээс сэргийлж трасс дагуу бүтээн байгуулалтын ажил хийж байгаа компани, хувь хүмүүстэй хамтрах, байнгын трасс дагуу эргэлт хийх, үзлэг үйлчилгээгээр гарч болзошгүй гэмтэл саатлыг илрүүлж өөрсдийн нөөц бололцоогоор засварлах зэрэг аль болох гэмтэл гаргахгүй байх нөхцөл бололцоог бүрдүүлэн ажиллаж байна.

Зураг 4. Шилэн кабелийн гэмтлийн төрөл




Өгөгдлийн сүлжээнд: Тайлант хугацааны хувьд нийт 40 удаагийн гэмтэл гарч 209.98 цаг үргэлжлэн 27936 Мбит/с урсгал саатсан.

Хүснэгт 3. 2024 оны Өгөгдлийн сүлжээнд гарсан гэмтлүүд

Төрөл	Удаа	Гэмтэл үргэлжилсэн хугацаа цаг	Саатсан урсгал Мбит/с
Тоног төхөөрөмжийн гэмтэл	24	168.71	11593
Программ хангамжийн гэмтэл	8	9.4	11211
Холбох хэрэгсэл	3	24.33	1456
Зай тэжээлийн гэмтэл	2	4.8	834
Хүний буруутай	3	2.74	2842
Нийт дүн	40	209.98	27936

Зураг 5. Гэмтлийн төрөл, удаа



2024 оны 6 болон 7 дугаар сард байгаль цаг уурын нөлөөтэй дуу цахилгаантай бороо их орсны улмаас өгөгдлийн сүлжээний төхөөрөмжид аянга бууж свитч шатах, систем доголдсон гэмтлүүд голчлон гарсан.

Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Хөвсгөл, Дорнод, Дундговь аймгуудад аянга орсноос болж систем доголдож төхөөрөмж гэмтсэн 9 удаагийн тоног төхөөрөмжийн гэмтэл гарсан. Аянга зайлуулагч болон газардуулгын чанарыг сайжруулах шаардлагатай байгаа болно.

Улс хоорондын сүлжээнд нийт 2 удаагийн гэмтэл гарч 13.8 цаг үргэлжлэн 440000 Мбит/с урсгал саатсан.


Кабель шугамын байгууламжийн сүлжээнд: Орон нутаг болон УБ хотын сүлжээ ашиглалтын газарт нийт 24 удаагийн гадны нөлөөтэй гэмтэл гарч 85 цаг үргэлжлэн зассан.

Хүснэгт 4. 2024 оны Кабель шугамын байгууламжид гарсан гэмтлүүд

Төрөл	Удаа	Гэмтэл үргэлжилсэн хугацаа /цаг/
Гол кабель	2	20
Салбар кабель	11	18
Худаг сувагчлал	11	47
Нийт дүн	24	85

Кабель шугамын байгууламжийн гэмтэл саатлын төрлөөр нь үзүүлбэл: Гол кабелийн гэмтэл 2 удаа, салбар кабелийн гэмтэл 11 удаа, худаг сувагчлалын гэмтэл 11 удаа гарсан байна.

Зураг 6. Худаг сувагчлал кабель шугамын гэмтэл



Салбар кабелийн муфьтний битүүмж муудсантай холбоотойгоор газар гэсэх үед буюу 3-5 дугаар сарын хооронд кабелийн гэмтэл өссөн.

Орон нутаг, ашиглалтын газруудын хариуцаж байгаа сайт/сумын салбарын тооноос хамаарч үндсэн сүлжээ, өгөгдлийн сүлжээ, улс хоорондын сүлжээний бэлэн байдал буюу KPI үнэлгээг тооцон гардаг.

Үндсэн сүлжээнд нийт 323 сум суурин газар холбогдож E1, STM, IP холболтоор 71.8 Гбит/с урсгалын трафик ачааллан орон нутгуудад харилцагч компаниудын үйлчилгээг хүргэж байна.

“Технологийн бараа, ажил үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавих журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж дараах чиглэлээр хяналтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Компанийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан нийт 45 ажлын 42 ажилд нь гэрээ байгуулагдсан. Тайлант хугацаанд бүрэн хэрэгжиж дууссан 31 ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ашиглалтад хүлээн авах акт бүрдүүлэлтийн материалыг хянаж, худалдан авах ажиллагааг дүгнэж үнэлгээ өгч ажилласан.

Аймаг, дүүрэг, ашиглалтын газруудаас 2024 оны Үндсэн сүлжээний урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээ хийх төлөвлөгөөг авч нэгтгэн, журмаар батлагдсан “УСҮҮ-ний шалгах хуудас”-ний дагуу үзлэг үйлчилгээг хийлгүүлж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үзлэгийн чанарт үнэлэлт дүгнэлт өгч үр дүнг тооцож ажилласан. 2024 оны УСҮҮ-ийн чанарын гүйцэтгэлийн үнэлгээ 92.97%-тай гарсан.

Төлөвлөгөөт Ажлын Гүйцэтгэлүүд:

- Мобиком-63, Жи-Мобайл-6, Скайтел-9 нийт 55 сайтыг оператор компаниудад шинээр нэмэгдүүлж үүсгэж өгсөн.
- Нөөц тэжээлийн үүсгүүрийн программын бодлогын даалгаврыг боловсруулж, шинээр программчлал хийж дууссантай холбогдуулан программд Мобиком ХХК-ийн 170

генератор, тогтмол тэжээлд холбогдсон 39 газар, цахилгаан эрчим хүчний шугам түрээсэлсэн 13 газрыг, Жи-Мобайл ХХК-ийн 166 генератор, тогтмол тэжээлд холбогдсон 22 газар, цахилгаан эрчим хүчний шугам түрээсэлсэн 17 газрыг, Скайтел ХХК-ийн 130 генератор, тогтмол тэжээлд холбогдсон 23 газар, цахилгаан эрчим хүчний шугам түрээсэлсэн 11 газрыг гэрээ биллийн программд шинээр бүртгэн оруулсан.

- Жи-Мобайл, Скайтел компанийн холын сайт, ойрын сайтыг тулгаж, холын сайтын км-ыг программд оруулсан. Мобиком ХХК-ний сайт эргэлтийн мэдээг Face2.0 програмд өдөр бүр оруулж байгаа эсэхийг хянаж хэвийн ажиллагааг хангаж ажиллалаа.
- 2024-2025 оны даатгалд хамруулах компанийн хот хоорондын шилэн кабелийн эрсдэлтэй трасс, УБ хотын кабель шугамын байгууламж, УБ хот болон аймгуудын барилга байгууламж, цамхаг, дамжуулах тоног төхөөрөмжийн судалгааг аймаг болон ашиглалтын газруудаас авч санхүүгийн хэлтсээр баланс үнийг тогтоолгож эд хөрөнгийн даатгалын техникийн даалгаврыг боловсруулж батлуулсан.
- Байгууллага, иргэнээс ирсэн кабель шугамын техникийн нөхцөл хүссэн хүсэлтийн дагуу нийт 861 техникийн нөхцөл батлуулан олгосон.
- Газар шорооны ажил хийхэд худаг сувагчлалын тодруулгыг нийт 368 чиглэлд хийсэн.
- КШ-ын техникийн нөхцөлийн дагуу гарсан техникийн шийдлийг 155 гадна холбооны ажлын зурагт тусгасан эсэхийг зөвшилцөн баталлаа.
- Шинээр хийгдсэн худаг сувагчлал болон кабель шугамын байгууламжийн мэдээллийг үндсэн дэвсгэр зурагт оруулах, мэдээллийн санг баяжуулах ажлын хүрээнд угсралт суурилуулалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудын шинээр хийж гүйцэтгэсэн 76 объектын худаг сувагчлалын гүйцэтгэлийн зургийг хийсэн.
- Компанийн Дэд бүтцийн газар, барилга байгууламж, цамхаг, тоног төхөөрөмжийн бүртгэлд 98% баяжилт хийсэн. Газрын гэрчилгээ, кадастрын зургийг хянах дутууг оруулах ажил 95% хийгдсэн. 2024 оны УСҮҮ-гээр байр, цамхгийн фото зургуудыг шинэчлэн авч, мэдээллийн нэгдсэн санд 50% баяжилт хийсэн.
- Дэвсгэр зургийн цэгцлэлтийн ажлыг КШТ-34 хүрээнд Мобиком дата төвийн сувагчлалаас яармаг хүртэлх 7ш plansheet дээр ажилласан.
- Сэлбэ сэргэлт Багц-1 хүрээнд 100 айлын гүүрнээс хойш далангийн баруун талын 2.5км авто замын трасс дагуух шинээр суурилуулах 4+0 эгнээ сувагчлал нь түвшингийн зөрүү болон далангийн хамгаалалтын торноос болж худаг суурилуулах зайгүй болсон талаар зургийн компанитай уулзалт хийж, ямар худаг суурилуулж болон талаар шийдэл гаргаж суурилуулах худгийн хэмжээг автокад зургаар гаргаж өгсөн.
- Төв аймгийн Баянчандмань сумын 2-р багийн нутаг дэвсгэрт байрлах үндсэн сүлжээний шилэн кабелийн трассыг шилжүүлэх ажлын хүрээнд 2.52км газарт 180 цэгийн хэмжилт хийсэн.

ХОЁР. ТӨЛӨВЛӨСӨН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТ

2.1 ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Улс болон хот хоорондын дамжуулах сүлжээний хүрээнд:

Улс болон хот хоорондын дамжуулах сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагаанд 24/7 цагийн хяналт тавьж, салбаруудын техникийн бэлэн байдлыг хангуулах, гэмтэл саатлын үеийн хяналтын хугацааг мөрдүүлэх, ашиглалтын үйл ажиллагааг технологийн шуурхай удирдлагаар хангаж ажиллалаа.

2024 онд SDH болон IP суурьтай дамжуулах сүлжээг шинэчлэх, өргөтгөх, найдвартай ажиллагааг дээшлүүлэх зорилгоор PTN төслийн хүрээнд Улаанбаатар болон 21 аймгийн төв 279 суманд суурилагдах тоног төхөөрөмжүүдийн угсралт суурилуулалт, хэмжилт тохиргоо, шилжүүлгийн ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч хойшлогдсон.

Иймээс өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан IP сүлжээний өргөтгөл, шинэчлэл, найдвартай ажиллагааг дээшлүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Булган аймгийн Гурванбулаг сумаас Өвөрхангайн Рашаант сум чиглэл, Сайншандаас- Айраг- Бор-Өндөр чиглэлд Скайнетворкс компанийн шилэн кабелиар, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумаас Толбо чиглэл, Дорнодоос Сүхбаатар чиглэл, Говь-Алтай аймгийн төвөөс Тайшир сум чиглэл нийт 5 чиглэлд нэмэлт холболт хийж баруун, зүүн чиглэлийн цагираг сүлжээний бэлэн байдлыг дээшлүүллээ.
- Архангай аймгийн Эрдэнэмандал, Хайрхан, Өлзийт, Батцэнгэл сумдад PTN төхөөрөмж шинээр суурилуулж өгөгдлийн сүлжээний трафик шилжүүлж ажиллалаа.
- Сэлэнгэ, Булган аймгийн төвийн өгөгдлийн сүлжээний харилцан холболтыг өргөтгөх, Багануур болон Сэлэнгэ аймгийн төвийн өгөгдлийн сүлжээний төхөөрөмжийг солих ажлууд тус тус хийгдсэн.
- Дамжуулах сүлжээний бэлэн байдал, найдвартай ажиллагааг дээшлүүлэх, өргөтгөл, оновчлол хийх зорилгоор 133 удаа сүлжээнд тасралт хийх мэдэгдлийг харилцагч байгууллагуудад хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж орон нутгийн инженерүүдтэй хамтран ажиллалаа.

Дамжуулах сүлжээний ашиглалт үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ:

- Улаанбаатар, Налайх, Зуунмод, Баянчандмань, Лүн, Алтанбулаг чиглэлүүдэд УСҮҮ-г тоног төхөөрөмж, шилэн кабель, зай тэжээлийн байгууламжид хийж сайжруулалтын ажлын төлөвлөгөө гаргасан. Сайжруулалтын ажлын төлөвлөгөөний дагуу 5 хэсэгт 7.2 км шилэн кабелийн сайжруулалтын ажлыг өөрсдийн нөөцөд тулгуурлаж хийлээ.

- Төвөөс алслагдсан РРШ-ын 104, 402, 403, 3К станцуудын үндсэн ажилчид тэтгэвэрт гарч оронд нь ажиллах хүн олдоггүй. Иймээс тус станцуудад дотор болон гадна талд IP камер суурилуулж DSS серверт хяналтыг оруулсан. Гэрээт ажилтан авч ажиллуулан долоо хоногт 2 удаа эргэлт хийлгэж байна.
- Багахангай төмөр замын холбоонд байрлах S151 шулуутгагчийн батерейг 1ш 100ah, 48V-ын батерейгаар сольж HUAWEI DWDM системийн зай тэжээлийн найдвартай ажиллагааг дээшлүүлэв. Мөн РРШ-ын 1К станцад Huawei ETP48300 шулуутгагч, 3ш 100А/Ц, 48В аккумулятор суурилуулан холболт хийж SDH системийн зай тэжээлийн найдвартай ажиллагааг дээшлүүллээ.
- УБ хотын болон орон нутгаас ирсэн 22ш гэмтэлтэй тоног төхөөрөмжийгн өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан засварлаж, 5ш төхөөрөмжийн гэмтлийг оношилж гэмтлийг тодорхойллоо.

2.2. УЛААНБААТАР ХОТЫН СҮЛЖЭЭ АШИГЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Улаанбаатар хотын хэмжээнд 6 дүүргийн нутаг дэвсгэр дээрх 9049 ш худаг, 636169 м сувагчлал, 3609 ш агаарын багана, кабель шугамын байгууламжийн техникийн бэлэн байдал, сүлжээний хэвийн ажиллагаа болон Нийслэлийн Мэдээлэл Шуурхай Төвийн дүүргүүдийн Цагдаа, Эмнэлэг, Онцгой Байдлын Газрууд, Гудамжны хяналтын камерууд, Яаралтай Тусламжийн Төвүүдийг холбосон агаар, сувагчлалаар явсан нийт 81.4 км шилэн кабель, Нийслэлийн Мэдээлэл Шуурхай Төвийн бүх дүүргийн Засаг Даргын Тамгын Газрын Даргын Газар, нийт Хороодуудыг холбосон 188.11 км шилэн кабель, Замын Хөдөлгөөний Удирдлагын Төвийн бүх дүүргийн авто замын гэрлэн дохио болон 1-р эгнээний хяналтын камеруудыг холбосон 127.8 км шилэн кабель, Мэдээлэл Холбооны Сүлжээ ХХК-ийн дамжуулах сүлжээгээр дамжиж байгаа улс хоорондох банкны урсгал, ТҮЦ машин, Дата төв, Хилийн Цэргийн Ерөнхий Газар, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар, Боловсролын яамны сургуулиуд, Тагнуулын Ерөнхий Газрын шилэн кабель зэрэг төр, хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийн сүлжээний найдвартай ажиллагаа ашиглалт үйлчилгээг хариуцан ажилладаг.

- Газрын хэмжээнд нийт 1201 цэгийн гэмтэл гарч хяналтын хугацаанд засварласан.
- Хуваарилах шүүгээ 151, агаарын багана 1185, кросын блок 703-д үзлэг үйлчилгээ хийсэн.
- Хайгуул хүсэлт 1495, боломжтой хэрэглэгч 1001, шинээр тавигдсан хэрэглэгч 406, шилжүүлэх үйлчилгээ хийгдсэн хэрэглэгч 145, гэрээ сэргээсэн 26, хэрэглэгч сулласан 2477,
- Гол кабелийн 48220*2 хос, Салбар кабелийн 48185*2 хосод төлөвлөгөөт тулгалт хийсэн.
- Гол кабелийн төлөвлөгөөт хэмжилтээр гол кабель 69920*2 хос, салбар кабель 30485*2 хос, цэгийн гэмтэл 152*2 хос, гомдол 35*2 хос, сул хосын гэмтэл 46*2 хос, цаг үеийн

- шаардлагаар урьдчилан сэргийлэх ажлын өмнөх 7830*2 хос, дараах гол кабель 2000*2, салбар кабель 730*2 хос, шинэ хүлээн авалтын 115*2 хос, төлөвлөгөөт УСА дараах 400*2 хосод тус тус нийт 111713*2 хосын хэмжилт хийсэн.
- Нийт 880 чиглэлд 9616 худагт эргэлт үзлэг хийсэн.
 - Дээвэр 11, таг хүзүү шинээр 127 суурилуулж, 35 таг хүзүү шилжүүлж, 199 худгийн ус шавхаж, 687 худгийн хог цэвэрлэж, 16 худаг өндөрлөсөн.
 - Станц хоорондын болон ашиглалт үйлчилгээ хариуцаж байгаа газруудын шилэн кабелийн 24 гэмтэл засварлаж 81 чиглэлд 1144 худагт шилэн кабелийн гүйцэтгэлийг шалгасан.
 - Шинэ хүлээн авалтын гүйцэтгэлийн зургийн хэмжилтийг 56 чиглэлд 115 худаг, 6387 м сувагчлалд хийж газар дээр нь гүйцэтгэл шалгаж, 32 чиглэлд оруулгын паспорт, 96 худгийн паспорт зурж, 2012 худгийг мэдээллийн санд оруулж автокад программд тусгасан.
 - Шилэн кабелийн баяжуулалт 184 чиглэлд 2400 худгийн паспортод шинэчилсэн бүртгэл хийсэн.
 - Шилэн кабелийн шинэ хүлээн авалт 80 чиглэлд 325 худаг 83838 м сувагчлалтай ААН-ийн шилэн кабелийн акт хүлээн авч тусгасан.
 - Угсралтын компаниудын хийж гүйцэтгэсэн 198 ажлыг газар дээр нь шалгаж 295 худагтай худаг сувагчлалыг актаар хүлээн авсан.
 - Кабель Шугамын 36,63 тасгийн хүрээний Баянхошууны дэд төвийн 155 агаарын баганын судалгаа хийж, координатын цэгийг хэмжиж мэдээллийн санд оруулсан.
 - Газар шорооны ажлын тодруулгаар 23 ажилд хяналт тавин ажилласан.
 - Кабель шугам 32 тасаг 2050м, 36 тасаг 1460м, 63 тасаг 6570м, 68 тасаг 4090м. Нийт 14,170м 144 core кабель татсан.

2024 онд ачаалал их худаг сувагчлалын гол трассаар суурилагдсан насжилтын хугацаа дууссан ашиглалтгүй физик 6800 хос кабелийн 27513м урт кабелийг чөлөөлж, худаг сувагчлалын ачааллыг бууруулсан.

Тайлант хугацаанд КШ-32, 34, 36, 45, 68 хэсгийн 25 чиглэлийн худаг хооронд сунасан 723 ширхэг кабелийн хэмжилт, хураалтын ажлыг газар дээр нь хянаж ажиллалаа. Эдгээр худаг хооронд ашигласан 6000х2 төрлийн кабелийн нийт урт, хосын тоог нарийвчлан бүртгэж, нийт 24,733.9 метр кабелийг хураах ажлыг гүйцэтгэсэн. Хураах боломжгүй үлдсэн 2,941.6 метр кабелийг үлдэгдэлд бүртгэн, цаашид шийдвэрлэх шаардлагатай байгааг тодорхойлсон. Ажлын явцад кабелийн трасс өөрчлөгдсөн тул худаг хоорондын хэмжилтийг дахин хянаж, хэмжээсийн зөрүүг тогтоон, гаргаж чадаагүй нисэлтийн кабелийн бүртгэлийг шинэчлэн хөтөлсөн. Энэ бүх үйл явцыг нарийвчлан хянаж, ажлын чанарыг сайжруулах чиглэлд анхаарч ажиллалаа.

Хүснэгт 5. 2024 онд худаг сувагчлалаас физик кабелийг чөлөөлсөн гүйцэтгэл

КШТ	Кабелийн багтаамж /хос/	Төлөвлөсөн кабелийн урт /м/	Чөлөөлсөн кабелийн урт /м/	Гүйцэтгэл /%/
32	1300	4597	3740.3	81%
34	200	772	341	44%
36	1100	4052	4115.6	102%
45	2800	11755	10890	93%
68	1500	6337	5703	90%
Нийт	6900	27513	24789.9	90%

2.3 ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Дотоод хяналт, шинжилгээний алба нь 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд компанийн газар, хэлтсүүдийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, эрсдэлийг тодорхойлох, бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр албан даалгавар, зөвлөмж өгч, гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр ханган, шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллалаа.


2024 оны эхний 10 сарын байдлаар орон нутгийн газруудаас Багануур, Хэнтий, Завхан, Архангай, Дундговь, Өмнөговь аймгийн газруудын 2022, 2023 оны зорилтот түвшний болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүн, Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж гүйцэтгэлээ. 2024 оны 11 сарын 06-аас Стратеги, санхүү, борлуулалтын газарт хяналт, шинжилгээ үнэлгээний ажил эхлүүлээд байна.

Төлөвлөгөөт ажил, хяналт, шинжилгээ үнэлгээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Багануур дүүрэг, Хэнтий аймаг, Завхан аймаг, Архангай аймаг, Дундговь аймаг, Өмнөговь аймгийн газруудын 21 сум, 9 РРС, 13 сайтын байр талбай, цамхагийн ашиглалт, техникийн бүрэн бүтэн байдал, техникийн ашиглалт үйлчилгээ, ХАБЭА-н нөхцөл байдал, компанийн болон төслийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудтай танилцан, газар дээр нь ажиллаж, мэргэжил, арга зүйгээр ханган, зөвлөмж, туслалцаа үзүүлэн ажиллалаа.
- Компанийн 2024 оны 1, 2, 3-р улирлын Шилэн дансны цахим системийн хөтлөлт, Шилэн дансны тухай хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтэнд улирал тутам хяналт хийж, ЗГХЭГ болон ЦХХХЯ-д тайланг хүргүүлж байна.
- Орон нутгийн газруудаас Багануур дүүрэг, Хэнтий аймаг, Завхан аймаг, Архангай аймаг, Дундговь аймаг, Өмнөговь аймгийн газруудын үйл ажиллагаанд илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах, эрсдлийг бууруулах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хийх шаардлагатай ажлуудыг тусгасан нийт 6 аймагт 168 заалт бүхий хугацаатай албан даалгавруудыг хүргүүлэн ажиллав.

- Дээрх газруудад хийгдсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлтийг үндэслэн компанийн бодлого, чиглэл хариуцсан холбогдох газар, хэлтсүүдэд зөвлөмжүүдийг хүргүүлээ.
- 2023 онд хяналт, шинжилгээ үнэлгээ хийгдсэн газруудаас өгөгдсөн албан даалгавар, зөвлөмжийн биелэлтийн тайланг хүлээн авч, биелэлт, үр дүнд хяналт, үнэлгээ хийж байна.
- Төв компанийн болон орон нутгийн газруудын удирдлагууд, ерөнхий инженер, ИТА, санхүүгийн ажилтнууд, ялангуяа шинээр томилогдсон ажилтнуудын мэргэжил, ур чадвар, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, сургаж дадлагажуулах, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэв.

2.4 ХӨГЖЛИЙН КАПИТАЛ-ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР



ХУУЛИЙН ХЭРЭГ ЖИЛТГИЙН ХАНИ АХ ЧИГЛЭЛЭЭР:

- Компанийн хэмжээнд “Тайлан, төлөвлөгөө боловсруулах, ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам”, “МХС ХХК-ийн нууцын журам”-ын төслийг боловсруулж, газар нэгжүүдээр хэлэлцүүлсэн санал авч, Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
- Компанийн эзэмшлийн 7 газрын хугацаа сунгах ажлын гүйцэтгэлийг хийж ажилласан.
- МХС компанийн дүрмийн өөрчлөлт орж төсөл боловсруулж, батлуулсан.
- Компанийн эрх бүхий 20 албан тушаалтны ХАСУМ-ыг АТГ-т хянуулж, 100 албан тушаалтны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд хүлээн авч, бүртгэсэн.
- Борлуулалт үйлчилгээ болон Түрээсийн гэрээтэй холбоотой бүх төрлийн гэрээнд хуулийн нийцлийг хангаж ажиллаж байна.
- Шилэн дансанд 3 төрлийн 97 мэдээллийг оруулж тайлагнасан.

СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сургалт хөгжлийн хэлтэс нь 2024 оны төлөвлөгөөний дагуу сургалтын төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг сайжруулах, ёс зүй хандлагыг дээшлүүлэх зорилгоор сургалтуудыг зохион байгуулан ажиллалаа.

Нийт 6 төрлийн сургалтад давхардсан тоогоор 2944 инженер техникийн ажилтан хамрагдсан байна.

**СУРГАЛТЫН
ХӨТӨЛБӨР
БОЛОВСРУУЛАЛТ**

Мэдээлэл дамжуулагч
болон кабель тавигч
РС 7422-15

Компьютерийн
Операторчин
Ю 4120-13

ХАБЭА-ийн Сургалт
Ажилтны | Олон нийтийн | Ажил олгогчийн

Дараах чиглэлээр багц сургалтуудыг зохион байгуулж 516 удирдах ажилтан, ИТА-дыг хамруулсан. Багц сургалтад нийт 211 удирдах албан тушаалтан, инженер техникийн ажилтнууд хамрагдсан байна. Үүнд:

- Удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн
- “Салбарын ажиллагсдын цугларалт-2024” арга хэмжээ
- Шинэ программ, ашиглалт үйлчилгээний сургалт

Сургалт, хөгжлийн хэлтэс нь үндсэн сургалтын эрхийн хүрээнд 6 удаагийн төлбөртэй сургалтыг зохион байгуулж 673 иргэнийг хамруулан, мэргэжил эзэмшүүлэн, чадамжийн гэрчилгээг амжилттай олгосон.

- Мэдээлэл дамжуулах болон холбооны кабель тавигч” мэргэжил олгох түр сургалт-2
- Нийт ажилтны ХАБЭА сургалт, Ажил олгогч болон удирдлагуудын ХАБЭА сургалт-2

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод сургалтуудыг хуваарийн дагуу зохион байгуулж, нийт 1228 ажилтныг хамруулав.

- Сискогийн /CCNA/ I шат сургалтад ДСАГ-ын 15 ажилтан онлайнаар хамрагдаж, 70 цагийн хичээлийг хөтөлбөрийн дагуу суралцаж сертификатаа авлаа. Сургалтыг Сискогийн үндсэн 2 сургагч багштай болсон.
- “Udemy” сургалтын платформд 21 эрх авснаас 15 нь аймаг дүүргийн газар, 6 эрхийг Улаанбаатар хотын газар, хэлтсийн хэрэглэгч эзэмшиж байна. Нийт 37 хэрэглэгч хандаж байгаагаас 6 хэрэглэгч сертификатын болзол хангасан.
- ISO 370011:2016 Авлигын менежментийн тогтолцооны стандартын сургалтад хамрагдан сертификатаа гардав.
- Нийт ажилтны ХАБЭА-н сургалт / Завхан, Дорнод, Хэнтий, Багануур/
- Ажил олгогч болон удирдлагуудын ХАБЭА сургалт
- Үйлдвэрлэлийн осол хурц хордлого судлан бүртгэх
- Галын аюулгүй байдлын сургалт
- SMART Marketing Conference

- Барилга байгууламжийн мэдээлэл, холбоо, дохиоллын зураг төслийн анхан шатны сургалт
- ЦЕГ-тай хамтарсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хуулийн мэдлэг олгох сургалт
- “Байгууллагын архивыг бүрдүүлэх нь”, “Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавигдах шаардлага” сэдэвт сургалт

ЦАХИМ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Компанийн дотоод үйл ажиллагаанд “Байгууллагын нөөцийн удирдлагын систем буюу ERP” системийг ашиглаж байгаа бөгөөд дэд системүүдийн ажиллагааг дараах байдлаар үнэлж байна. Үүнд:



Системийн хэвийн ажиллагааг хангахын тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Дэд системүүд болон нэгжийн удирдлага, ажилтны үйлчилгээ холбоос системүүдийн ашиглалттай холбоотойгоор 1362 үндсэн /ажилтны/, 229 гэрээт хэрэглэгчийн хүрээнд 14 дэд системийн ашиглалтын шуурхай байдлыг бүрэн хангаж зөвлөгөө, зааварчилгаа өгч ажиллаа.
- УБ хот, аймаг дүүргийн газрын ажилтнуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу зөвлөн туслах үйлчилгээг тасралтгүй хүргэсэн бөгөөд ERP системийн ашиглалт болон Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр аймаг, дүүргийн газруудад бүсчилсэн цахим сургалтыг 2 удаа зохион байгуулсан.
- Системийн алдаа, сайжруулалтын 80 санал хүсэлт бүртгэгдсэнээс 75 санал шийдвэрлэгдэж, 93.75% санал хүсэлт шийдвэрлэсэн.
- Худалдан авах систем, Хүний нөөцийн систем, Ажил үүргийн систем, Цаг бүртгэлийн систем, Нэгжийн удирдлага, Ажилтны үйлчилгээ хэсгүүдэд нэмэлт хөгжүүлэлтүүдийг хийсэн.
- Ажилтнуудаас нийт 2508 удаагийн цагийн хүсэлт ирснээс зөвшөөрсөн хүсэлт 2031 байна. Мөн Худалдан авах ажиллагаатай холбоотойгоор 635 хүсэлт бүртгэгдэж шийдвэрлэгдсэн.
- Архив, албан хэрэг хөтлөлтийн журмын төслийг боловсруулан хуулийн хэлтэст хянагдаж байна. ДХША, ТӨБЗГ болон Төрийн аудитын байгууллага, бусад хяналт,

шалгалтын байгууллагуудад 2024 оны эхний 10 сарын ирсэн, явсан бичгийн хадгаламжийн нэгжийг бэлтгэж, материалуудыг PDF файлаар, жагсаалтын хамт илгээж амжилттай шалгуулсан.

- УБ хотын хэмжээнд харилцагч байгууллага, компани, хувь иргэдээс ирсэн албан бичиг, хүсэлтүүд 2205-г уламжлалт болон цахимаар бүртгэсэн. Мөн компанийн хэмжээнд нийт 1504 техникийн нөхцөлийн хүсэлт шинээр системд бүртгэсэн.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

Компанийн ажилтнуудын ажлын байрны аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

- Компанийн Гамшгаас хамгаалах штабын гишүүд, ҮОХХСБК-ийг бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирлын тушаалаар шинэчлэн батлуулсан.
- УБ хотын хэмжээнд шаардлагатай бүх төрлийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тухай бүр өгч ажилласан бөгөөд урьдчилсан аюулгүй ажиллагааны зааварчилгааг 40, албан томилолтоор ажиллах үеийн зааварчилгааг 271 нийт 311 ажилтан зааварчилга өгсөн байна.
- Эрсдэл өндөртэй ажлын байранд ажилладаг ажилтнуудын судалгааг шинэчлэн амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулах ажилтнуудын судалгааг ТУТГ-т хүргүүлж 21 инженер техникийн ажилчдын даатгалд нэмэлтээр хамруулж, даатгалын гэрээнд тодотгол хийгдсэн. Нийт 159 инженер техникийн ажилчдыг даатгалд хамруулсан.
- ХАБЭА-н 2 болон 3 шатны үзлэгийн хүрээнд объектуудад тогтмол үзлэг шалгалт хийж гарсан зөрчлүүдийг тайлангаар танилцуулж хугацаатай үүрэг өгч ажилласан.
- “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага, сургуулийг компанийн хэмжээнд зохион байгуулж тайланг ОБХ хүргүүлж ажиллалаа.
- Компанийн ХАБЭА дүрэм, Ажлын хувцас, гутлын журам, ААЗ өгөх журам, Хяналт хийх журам, Аюулыг мэдээлэх хуудасны журам, Галын дүрэмд тодотгол хийж гүйцэтгэсэн.
- Аюулгүй ажиллагааны 22 төрлийн 717 ширхэг тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байршуулсан.
- “Ажлын тусгай хувцас олгох журам”-ын дагуу 2024 онд захиалагдах ажлын тусгай хувцас, гутлын захиалгын дагуу олгосон. УБ хотын хэмжээнд ажлын багаж, хамгаалах хэрэгслийн захиалгын дагуу олгосон. /Дөрөө, бүс, өндрийн бүс, ажлын багажийн цүнх/
- Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний удирдлага зохион байгуулалтын дүрэм журмын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хэвийн ажиллагааг хангаж ажиллалаа. 429 ажилтанд давхардсан тоогоор артерийн даралт хэмжих-656, албан томилолтоор явах ажилтны анхан шатны үзлэг судас тариа 80, дусал тариа 690, булчин тариа 128 ажилтанд хийсэн бол толгой хүзүүний бариа 171, бумба

- 172, УВЧ шарлаг 298, искра шарлаг 4, парпин лаа 82, шарх цэвэрлэж боолт 15, анхан шатны эм тариагаар 95 ажилтанд тусламж үйлчилгээг хүргэсэн байна.
- УБ хотын ДСАГ, УБХСАГ-н 207 инженер техникийн ажилтныг 2 багц болгож эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулсан.
 - Албан томилолтоор орон нутагт ажилласан 156 ажилтанд, Налайх төвийн 12 ажилтанд, 1к-ийн 24 ажилтанд, РРС-дад ээлжээр ажиллах 50 ажилтанд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, ажилд гарах зөвшөөрөл өгч ажилласан.
 - Гачуурт дахь 1980 онд баригдсан 165.60м.кв, ашигтай талбай 104.08 м.кв бүхий албан конторын зориулалттай 1 давхар холбооны барилгад үзлэгийн дүгнэлт хийж, холбогдох зардлын судалгааг гаргасан.
 - Наран төвийн барилгын гадна цэвэр, бохир усны шугам сүлжээний холбох хүсэлтийг УСУГ-т хүргүүлж техникийн нөхцөлийг гаргуулсан ба барилгын ус хангамж, ажлын зургийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулсан. Мөн гадна усан хангамжийн төсвийг гаргуулсан.
 - Өвөлжилтийн бэлэн байдлыг хангах үйл явцын хүрээнд ААҮХ, ДСАГ-ын ЗТХРР-ны хэлтэстэй хамтарч Улаанбаатар хотын бүх объектуудад үзлэг хийж, илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээний хүрээнд холбогдох газар хэлтэст мэдэгдэж, хариу арга хэмжээ авах чиглэлийг өгч ажилласан.
 - УБ хотын объектуудад ариутгал, халдваргүйжүүлэлт хийх шаардлагыг ААҮХ-т хүргүүлж, ариутгал, мэрэгч амьтан, шавж устгалыг хийхэд хяналт тавьж ажилласан. Мөн Төв байрны 6 ширхэг усны аппаратын шүүлтүүрийг 3 удаа солиход хяналт тавьж ажилласан.
 - Орон нутагт томилолтоор ажилладаг тээврийн хэрэгсэлд анхны тусламжийн хайрцаг, даралтын аппаратыг байршуулсан.